| <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | <b>235,100,000.00</b> | <b>233,780,503.82</b>       | <b>1,319,496.18</b>      | <b>99%</b>  |
| Үндсэн цалин  | 140,600,000.00        | 143,881,782.97              | -3,281,782.97            | 102%        |
| Урамшуулал  | 54,000,000.00         | 49,565,232.20               | 4,434,767.80             | 92%         |
| Гэрээт ажлын хөлс   | 40,500,000.00         | 40,333,488.65               | 166,511.35               | 100%        |
| <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | <b>29,737,500.00</b>  | <b>29,719,500.00</b>        | <b>18,000.00</b>         | <b>100%</b> |
| Тэтгэврийн даатгал  | 20,573,500.00         | 20,217,802.05               | 355,697.95               | 98%         |
| Тэтгэмжийн даатгал  | 2,291,000.00          | 2,375,424.49                | -84,424.49               | 104%        |
| ҮОМШӨ-ний даатгал   | 1,832,800.00          | 1,900,339.59                | -67,539.59               | 104%        |
| Ажилгүйдлийн даатгал  | 458,200.00            | 475,084.90                  | -16,884.90               | 104%        |
| Эрүүл мэндийн даатгал   | 4,582,000.00          | 4,750,848.97                | -168,848.97              | 104%        |
| <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | <b>21,232,900.00</b>  | <b>17,527,341.04</b>        | <b>3,705,558.96</b>      | <b>83%</b>  |
| Гэрэл, цахилгаан  | 6,612,900.00          | 5,896,841.04                | 716,058.96               | 89%         |
| Түлш, халаалт   | 14,500,000.00         | 11,606,000.00               | 2,894,000.00             | 80%         |
| Цэвэр, бохир ус   | 120,000.00            | 24,500.00                   | 95,500.00                | 20%         |
| <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>26,444,100.00</b>  | <b>25,844,100.00</b>        | <b>600,000.00</b>        | <b>98%</b>  |
| Бичиг хэрэг   | 2,499,000.00          | 2,068,250.00                | 430,750.00               | 83%         |
| Тээвэр, шатахуун  | 17,000,000.00         | 17,000,000.00               | 0.00                     | 100%        |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 2,265,100.00          | 2,093,665.60                | 171,434.40               | 92%         |
| Ном, хэвлэл   | 200,000.00            | 188,600.00                  | 11,400.00                | 94%         |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал       | 3,700,000.00          | 3,700,000.00                | 0.00                     | 100%        |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                     | 780,000.00            | 793,584.40                  | -13,584.40               | 102%        |
| <b>Нормативт зардал</b>   | <b>1,500,000.00</b>   | <b>1,500,000.00</b>         | <b>0.00</b>              | <b>100%</b> |
| Хоол, хүнс  | 1,200,000.00          | 1,200,000.00                | 0.00                     | 100%        |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл                                     | 300,000.00            | 300,000.00                  | 0.00                     | 100%        |
| <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>41,275,000.00</b>  | <b>30,306,515.60</b>        | <b>10,968,484.40</b>     | <b>73%</b>  |
| Багаж, техник, хэрэгсэл   | 17,140,000.00         | 12,871,516.00               | 4,268,484.00             | 75%         |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                    | 450,000.00            | 450,000.00                  | 0.00                     | 100%        |
| Урсгал засвар   | 16,985,000.00         | 16,984,999.60               | 0.40                     | 100%        |
| <b>Томилолт, зочны зардал</b>                                   | <b>4,500,000.00</b>   | <b>3,768,900.00</b>         | <b>731,100.00</b>        | <b>84%</b>  |
| Дотоод албан томилолт   | 4,500,000.00          | 3,768,900.00                | 731,100.00               | 84%         |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>1,130,000.00</b>   | <b>8,800,949.00</b>         | <b>-7,670,949.00</b>     | <b>779%</b> |

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|  |                       |                       |                      |             |
|--|-----------------------|-----------------------|----------------------|-------------|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00                  | 8,017,443.00          | -8,017,443.00        | 0%          |
| Даатгалын үйлчилгээ  | 330,000.00            | 330,000.00            | 0.00                 | 100%        |
| Тээврийн хэрэгслийн татвар   | 300,000.00            | 96,188.00             | 203,812.00           | 32%         |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 130,000.00            | 55,000.00             | 75,000.00            | 42%         |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 220,000.00            | 220,000.00            | 0.00                 | 100%        |
| Газрын төлбөр  | 150,000.00            | 82,318.00             | 67,682.00            | 55%         |
| <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>22,700,000.00</b>  | <b>18,842,284.00</b>  | <b>3,857,716.00</b>  | <b>83%</b>  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 22,100,000.00         | 18,320,484.00         | 3,779,516.00         | 83%         |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 600,000.00            | 521,800.00            | 78,200.00            | 87%         |
| <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>500,000.00</b>     | <b>250,000.00</b>     | <b>250,000.00</b>    | <b>50%</b>  |
| <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>500,000.00</b>     | <b>250,000.00</b>     | <b>250,000.00</b>    | <b>50%</b>  |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 500,000.00            | 250,000.00            | 250,000.00           | 50%         |
| <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>384,119,500.00</b> | <b>365,222,650.46</b> | <b>18,896,849.54</b> | <b>95%</b>  |
| <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>369,119,500.00</b> | <b>347,322,650.46</b> | <b>21,796,849.54</b> | <b>94%</b>  |
| Орон нутгийн төсвөөс   | 369,119,500.00        | 347,322,650.46        | 21,796,849.54        | 94%         |
| <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | <b>15,000,000.00</b>  | <b>15,000,000.00</b>  | <b>0.00</b>          | <b>100%</b> |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 15,000,000.00         | 15,000,000.00         | 0.00                 | 100%        |
| <b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>                             | <b>0.00</b>           | <b>2,900,000.00</b>   | <b>-2,900,000.00</b> | <b>0%</b>   |
| Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих                                    | 0.00                  | 2,900,000.00          | -2,900,000.00        | 0%          |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     | 0.00                  | 0.00                  | 0.00                 | 0%          |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    | 0.00                  | 0.00                  | 0.00                 | 0%          |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт   | Тайлант оны           |                     |
|--|-----------------------|---------------------|
|  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл           |
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | -                     | <b>14,297,993.0</b> |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | -                     | 14,297,993.0        |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | -                     | 8,017,443.00        |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | -                     | 8,017,443.00        |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       |                       | 8,017,443.00        |
| <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | -                     | 6,280,550.00        |
| <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | -                     | 6,280,550.00        |
| Төвлөрүүлэх шилжүүлэг  |                       | 6,280,550.00        |
| <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | -                     | <b>14,297,993.0</b> |
| <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | -                     | 14,297,993.00       |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | -                     | 2,900,000.00        |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | -                     | 11,397,993.00       |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | -                     | -                   |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>   | -                     | -                   |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төгрөг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Төгрөг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төгрөг сумын Засаг даргын тамгын газар нь: Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төгрөг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 338.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 439.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход 8.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 4.3 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төгрөг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.81 хувиар буюу 108.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 6.3 сая төгрөг нь шүлхийн үеэр гарсан авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 159.0 сая төгрөг болж 29.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 68.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандиваар 0.2 сая төгрөгийн шилжүүлэн авсан 16.0 сая төгрөгөөр бараа авч, үйл ажиллагаандаа 56,3 сая төгрөгийн материалыг зарцуулж 2.3 сая төгрөгийн хөрөнгө акталж устгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1116.0 сая төгрөг болж 144.1 сая төгрөгөөр буурсан нь 16,6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан 2.3 сая төгрөгөөр хандив авсан, 5,0 сая төгрөгөөр Гишүүний хөрөнгө оруулалт авсан 5.7 сая төгрөгөөр сумын ОНХС-аас орлого авсан, 9.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 61.4 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 574,4 сая төгрөг, Хуримтлагдсан үр дүн 631.5 сая төгрөг, Тайлант оны үр дүн 108.6 сая төгрөг байна. Орлого өмнөх оноос 34 хувиар буюу 216.1 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 108.6 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 407.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 23.7 сая төгрөгөөр бууруулж, 384.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс буурсан байгаа нь цалингийн зардлыг бууруулсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 384.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 384.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 362.3 сая төгрөгийг зарцуулж 21.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс буцаан, орлого давсан дүнгээс 5.5 сая төгрөгөөр, шүлхийн төсөв 6.3 сая төгрөгөөр, нийт 33.5 сая төгрөг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 362.3 сая төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь Цалин хөлс 1.3 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 3.7 сая төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 0.6 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 0.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3.5 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 14.3 сая төгрөгийн орлого хүлээн авч, 8.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд, 6.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж авлага болгон тайланд тусгажээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 607.7 сая төгрөгийн 115 мэдээллийг ил тод байршуулахаас 607.7 сая төгрөгийн 115 мэдээллийг ил тод байршуулсан байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 3.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 95.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, сая төгрөгийн зөвлөмжийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна.

#### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараа жилийн аудитаар

- Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг авч үзэх
- Бараа материалын тайлангийн тулгалт,
- Хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэхийг шалгах
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг зүйтэй гэж үзлээ

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 69.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн алдааг залруулж, 7.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 59.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### 4.1 Залруулсан алдаа

Зардлыг түүвэрлэн үзэхэд 1.5 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Эд хөрөнгийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн тооллогоор 0.09 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан боловч төлүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4.5-т "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тайланд онд Засгийн газрын хэмнэлтийн горимыг зөрчиж 4.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн боловч одоо болтол хөрөнгө нь ирээгүй байна. Мөн тавилга, бараа материалаас 0.7 сая төгрөгийн аккумулятор, 2.6 сая төгрөгийн Хроп ирээгүй бөгөөд эд хөрөнгийн тооллогоор дутагдсан байгаа нь Төсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, Татварын тодорхойлолт 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Малчин айлын мал эзэмших гэрээний хугацаа дууссан байхад 169 толгой 10.6 сая төгрөгийн малыг дараагийн айлд шилжүүлэн өгөөгүй байгаа нь Малчинтай байгуулсан гэрээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох

бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Малчин айлын мал эзэмших гэрээний сунгалтыг хийгээгүй 52 толгой 37.7 сая төгрөгийн мал, 80 толгой 6.5 сая төгрөгийн малыг эзэмшигчидтэй огт гэрээ байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"-ыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс хоол хүнсний зардалд 1.8 төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагаатай Е баримтгүй 3.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |     |               |     |                 |      |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|------|---------|-----|
|     |                                     |                      |      | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |      | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн  | Тоо     | Дүн |
| 1   | Төгрөг сумын ЗДТГ                   | 6                    | 69.3 | 1         | 1.5 | 2             | 7.9 | 3               | 59.9 |         |     |